



ГУРВАН УЛИРЛЫН ХҮЛЭМЖ БАРИХ АЖЛЫН ҮНИЙН САНАЛ АВАХ УРИЛГА

ЭкоДэвшилт ТББ нь хэрэгжүүлж буй төслийн хүрээнд Хөвсгөл Аймгийн Алаг-Эрдэнэ сумын Хатгал тосгонд гурван улирлын 120 м2 бүхий, эрс тэрс уур амьсгалд тэсвэртэй 1 ширхэг хүлэмж барих гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах зорилгоор эрх бүхий байгууллагуудыг битүүмжилсэн үнийн санал ирүүлэхийг урьж байна.

Огноо:

2026 оны 3 дугаар сарын 16

Төслийн нэр:

ЮНЕСКО-гийн Шим Мандалын нөөц газар Хөвсгөл нуур – тогтвортой аялал жуулчлалаар нүүдэлчин малчин иргэдийн орлогын эх үүсвэр бий болгох төсөл, ЭкоДэвшилт ТББ

Үнийн санал авах нэр:

Гурван улирлын 120 м2 хүлэмж барих

Санал хүлээн авах огноо:

2026 оны 3 дугаар сарын 16-ны 12:00 хүртэл

Хүлэмжийн тоо:

Нийт 1 хүлэмж

Хүлэмжийн м2 хэмжээ:

120 м2 талбайтай.

Хүлэмж бариулах байршил:

Хөвсгөл аймгийн Алаг-Эрдэнэ сумын Хатгал тосгон

ЮНЕСКО-ГИЙН ШИМ МАНДАЛЫН НӨӨЦ ГАЗАР ХӨВСГӨЛ НУУР – ТОГТВОРТОЙ АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛААР НҮҮДЭЛЧИН МАЛЧИН ИРГЭДИЙН ОРЛОГЫН ЭХ ҮҮСВЭР БИЙ БОЛГОХ ТӨСЛИЙН тухай товч мэдээлэл:

ХБНГУ-ын Эдийн Засгийн Хамтын Ажиллагаа, Хөгжлийн Яам (BMZ) болон Дэлхийн Байгаль Орчны Сантай (GNF) хамтран “ЮНЕСКО-гийн Шим Мандалын Нөөц Газар Хөвсгөл Нуур - Тогтвортой аялал жуулчлалаар нүүдэлчин малчин иргэдийн орлогын эх үүсвэр бий болгох” 2024-2028 төслийг хэрэгжүүлж байна. Төслийн хүрээнд Хөвсгөл Аймгийн Алаг-Эрдэнэ сумын хог хаягдлын менежментийг сайжруулах, сүү, сүүн бүтээгдэхүүний үйлдвэрлэл, хүлэмжийн аж ахуй эрхлэх мэдлэг олгож, аялал жуулчлалын баазуудыг орон нутгаас нийлүүлэх органик хүнсний ногоо нийлүүлэлт, борлуулалтын сүлжээг бий болгох замаар малчин иргэдийн орлогын эх үүсвэрийг нэмэгдүүлэх зорилготой. Мөн орон нутгийн иргэдийг аялал жуулчлалын салбарт шаардлагатай ажлын байраар бэлтгэж, зочлох үйлчилгээний мэдлэг, ур чадварт суралцуулах багц сургалтуудыг зохион байгуулна.

1. Үндэслэл

Манай төсөл хэрэгжүүлж буй Хөвсгөл Аймгийн Алаг-Эрдэнэ сумын Хатгал тосгон нь Монгол орны хойд өндөрлөг бүсэд орших, сэрүүн эх газрын эрс тэс уур амьсгалтай бөгөөд жилийн дундаж температур бага, хяруу үүсэх хугацаа урт байдаг. Улмаас хүнсний ногооны тариалалтын хугацаа харьцангуй богино байдаг.

ЮНЕСКО-гийн Шим Мандалын Нөөц Газар Хөвсгөл Нуур– Тогтвортой Аялал Жуулчлалаар Нүүдэлчин Малчин Иргэдийн Орлогын Эх Үүсвэр Бий Болгох төслийн хүрээнд гурван улирлын хүлэмж барьснаар дараах үр дүнг хүлээж байна.

- Орон нутагт хүнсний ногооны хэрэгцээг хангах
- Жижиг талбайд тариалан эрхлэгчдийн орлогын эх үүсвэрийг нэмэгдүүлэх, тогтворжуулах
- Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох болон тэсвэртэй байдлыг нэмэгдүүлэх

Энэхүү ажлын шаардлагын дагуу Хөвсгөл Аймгийн Алаг-Эрдэнэ сумын Хатгал тосгонд нэг ширхэг гурван улирлын хүлэмжийн зураг төслийг боловсруулж, барилгын ажлыг гүйцэтгэснээр орон нутгийн хүнсний ногооны үйлдвэрлэл эрхлэгч хоршоодыг дэмжин, органик хүнсний үйлдвэрлэлийг хөгжүүлэх, борлуулалт, нийлүүлэлтийг сүлжээг өргөжүүлэх зорилготой.

2. Зорилго

Энэхүү ажлын даалгаврын үндсэн зорилго нь төслийн зорилтот суманд хүнсний органик хүнсний ногоо тариалах, нарийн ногооны хангамжийг нэмэгдүүлэх, мөн хамтран ажиллаж буй хоршооны гишүүдийн орлогыг нэмэгдүүлэх зорилгоор гурван улирлын хүлэмжийн зураг төслийг боловсруулж, чанарын шаардлага хангасан байдлаар барьж байгуулахад чиглэнэ.

Эдгээр хүлэмж нь эрт ургац авах боломжийг бүрдүүлж, зах зээлд нарийн ногооны нийлүүлэлт болон үнийг тогтворжуулахад хувь нэмэр оруулахын зэрэгцээ хоршооны гишүүдийн орлогын тогтвортой байдлыг хангах, амьжиргааг сайжруулахад чухал ач холбогдолтой юм.

3. Гүйцэтгэх ажил

Гүйцэтгэгч нь эдийн засгийн хэмнэлттэй, байгаль орчинд ээлтэй, Монгол орны цаг уурын нөхцөлд тохирсон гурван улирлын хүлэмжийн зураг төслийг боловсруулж, чанарын өндөр түвшинд барьж гүйцэтгэнэ. Уг ажил нь олон улсын

байгаль орчны стандартад нийцэж, тогтвортой органик хөдөө аж ахуйг дэмжих зорилготой. Дараах гол шаардлагуудыг харна уу:

1. Хүлэмжийн зураг төсөл, барилгын ажил

- Эдийн засгийн хэмнэлттэй, урт хугацааны тогтвортой ашиглалтыг эрхэмлэсэн, уур амьсгалын өөрчлөлтөд тохирсон (дулаалга, агааржуулалт, цэвдэг,хөлдөлт, цасны даац зэргийг анхаарсан) загвар зураг боловсруулах.
- Хүлэмжийг сонгосон хоршоодын талбайд чанарын өндөр түвшинд, стандартад нийцсэн материал ашиглан барих.
- Шууд суурилуулахад тохиромжтой, цайрдсан, зэврэлтгүй ган хүрээ ашиглах.
- Барилгын салбарын хүлээн зөвшөөрөгдсөн стандартад нийцүүлэн, барьсан хүлэмжийн баталгаат хугацаанд чанарын өндөр түвшинд барьж өгөх.

2. Материал

- Цайрдсан/зэврэхгүй/ ган төмөр хийц (шууд угсрах)
- Хүлэмжийн бүх холбох хэрэгсэл нь стандартын шаардлага хангасан
- 12 мм-ээс доошгүй зузаантай сайн чанарын хамгаалалтын хальс
- Чийг үл нэвтрэх дулаан хадгалах давхар хучлага
- Дулааны хучлага нь механик эсвэл цахилгаанаар ажилладаг
- Гурван талын хана барих материалд: Дулаан хадгалах, ус чийг даах чадвартай чанарын шаардлага хангасан материал байх \цемент, элс, хайрга, 300-400 мм-ийн зузаантай хийцэт бетон блок, эмульс, шохой\ хүлэмжийн горимд нийцсэн цонх, хаалгатай байх

3. Байгаль орчны тогтвортой байдал (Байгаль орчны болон нийгмийн эрсдэл)

- Ажил гүйцэтгэгч нь хүлэмж барих материал сонгохдоо байгаль орчинд ээлтэйгээр бодож төлөвлөх. /хадгалалт, тээвэрлэлт, баглаа боодол/
- Хүлэмж барих материал нь урт удаан хугацаанд ашиглагдах чанарын шаардлагыг хангасан байх /шаардлага хангасан гэрчилгээтэй

- шинжилгээний бичигтэй байх, урьд хэргэлж байсан туршлага түүхийг харгалзан үзэх/
- Хүлэмжийн барилга болон хэрэглэж буй тоног төхөөрөмж нь дахин ашиглагдах боломжтой байх
- Ажил гүйцэтгэгч нь тухайн орон нутгийн хүмүүсийг сонгон ажлын байраар хангах
- Хүлэмжийн хийн ялгаралтын хэмжээг бууруулах технологийг ашиглах
- Нар, салхины эрчим хүчийг ашиглах технологийг тусгах
- Хүлэмж барих материал нь Монгол улсын барилгын материалын стандарт шаардлагыг хангасан байх
- Хүлэмж барих явцад хэрэглэх ус нь аль болох саарал болон борооны усыг ашиглах
- Хүлэмж барихдаа ойр орчны газар, ургамлын ургалтыг алдагдуулахгүйгээр зохицуулан тээвэр, материалын хадгалалт өрөлтөд дээр анхаарах. Мөн тухайн хүлэмж барих газрын урсгал ус, худгийн нөөцийн тогтолцоог алдагдуулахгүй байх
- Тухайн ажил гүйцэтгэгч нь ажилтнуудын хөдөлмөрийн хөлсийг Монгол улсын баталсан хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс буулгахгүй байх, ажлын байр нь эрүүл аюулгүй байдлын норм нормативыг хангасан байх
- Тухайн ажил гүйцэтгэгч нь хүүхдийн хөдөлмөрийн мөлжлөг, хүйсийн ялгаварлан гадуурхалт, үндэсний цөөнхийг ялгавартай харьцаагүй ажлын орчин бүрдүүлэх

4. Чадавх бэхжүүлэх

- Хоршооны гишүүдэд хүлэмжийн аж ахуй, анхан шатны засвар үйлчилгээний талаар практик сургалт зохион байгуулна. Монгол хэл дээр энгийн хэрэглэгчийн гарын авлага боловсруулж өгнө

4. Техникийн үзүүлэлт

Хэмжээ:	120 мкв (жишээлбэл, стандартын дагуу 6×20 метр)
Дээвэр:	Цайрдсан ган материалаар хийгдсэн байх
Хучлага:	Хэт ягаан туяанд тэсвэртэй полиэтилен
Агааржуулалт:	Дээврийн болон хажуугийн агааржуулалт/механик ажиллагаатай систем/

Дулаан: Дулааны алдагдал маш бага байхаар тооцож дулаалгыг хийж өгөх
Суурь: Хөрсний хөлдөлтөөс тусгаарласан, найдвартай бэхэлгээтэй байх

5. Тогтвортой байдал

Хүлэмжийн барилга нь худалдан авалтын бодлого, тогтвортой байдлын дараах зарчмуудыг баримтлах ёстой.

- **Экологи:** Ус, эрчим хүчний нөөцийг үр ашигтай ашиглах, хуванцар хог хаягдлыг багасгах, байгальд ээлтэй материал ашиглах.
- **Нийгэм:** Орон нутгаас ажиллах хүч авах, хүүхэд ажиллуулахгүй байх, хийсэн ажилд тохирсон цалин хөлс олгох, жендерийн мэдрэмжтэй үйл ажиллагаа явуулах.
- **Эдийн засаг:** Хэрэглэгчдэд үр ашигтай, ашиглалтын хугацааг аль болох урт байлгах.
- Хүлэмжээ хүлээлгэн өгөхдөө ашиглах хугацааг уртасгах арга барилыг хэрэглэгчид зөвлөх.
- **Эрсдэлийн менежмент:** Шуурга, үер, ус зэрэг эрсдэлээс урьдчилан сэргийлэх зөвлөмж өгөх.

6. Гүйцэтгэл

- Хөвсгөл Аймгийн Алаг-Эрдэнэ сумын Хатгал тосгонд хүлэмж барих
- Хэрэглэгчдэд ашиглалтын гарын авлага бэлдэж өгөх
- Хүлэмж барих хугацаат төлөвлөгөөг гаргаж өгөх.Үүнд:
 - Барилгын зураг нь хүлэмжийн материалын тооцоотой байх.
 - Материалын чанарыг тодорхойлсон лабораторийн шинжилгээний тайланг багтаасан байх.
 - Хүлэмжийн системийн суурилуулалтын төлөвлөгөө (агааржуулалт, халаалт, хөргөх, усалгаа, цахилгаан, сэргээгдэх эрчим хүч).
 - Хүлэмжийн барилгын материалын тоо хэмжээний жагсаалт (BOQ).
 - Хүлэмж барих хугацааны төлөвлөгөө.
- Усалгааны систем
 - Эх үүсвэр, төрөл, байршил
 - Ажиллах заавар, Засвар үйлчилгээ
 - Бусад зөвлөгөө

- Цаг уурын хяналтын систем
 - Орчны дулаан хэмжих
- Хүлэмжийн дулааны тохиргоо, салхижуулалт
 - Хүлэмжийн чийгийн хяналт
- Захиргааны бичиг баримт
 - Барилгын стандарт, аюулгүй ажиллагааны журам, байгаль орчны стандартуудыг мөрдөх
 - Баталгааны бичиг
 - Гэрээ, хэлцлийн хуулбарууд

7. Хугацаа

Гурван улирлын хүлэмжийг доорх сарын хугацаанд барьж дуусгана.

№	Үйл ажиллагаа	Хугацаа
1	Тендерийн зар тавих	2026 оны 3 дугаар сарын 16-аас 3 сарын 30
2	Тендерийн сонголт	4 сарын 1-3-ны өдрүүдэд
3	Гэрээ байгуулах	4 сарын 6-10
4	Материалын таталт худалдан авалт	4 сарын 13 – 4 сарын 20
5	Суурийн нүх ухах, суурь цутгах	4 сарын 20 – 5 сарын 2
6	Хана өрөх	5 сарын 4
7	Дээврийн угсралт	5 сарын 11 -16
8	Хучилт, дээврийн дулаалгыг угсрах	5 сарын 17- 22
9	Хүлээлгэн өгөх - Хүлэмж	5 сарын 30

8. Үүрэг, хариуцлага

- Хэрэгжүүлэгч (ЭкоДэвшилт ТББ-ын, ЮНЕСКО-гийн Шим Мандалын нөөц газар Хөвсгөл нуур – тогтвортой аялал жуулчлалаар нүүдэлчин малчин иргэдийн орлогын эх үүсвэр бий болгох төсөл): Ерөнхий зохицуулалт, байнгын хяналт, чанарын үнэлгээ, хоршооны гишүүдийн оролцоог хангах, орон нутгийн хэрэгжилтийг хангах.
- Хоршоо: Барилга угсралтын ажилд хяналт тогтмол тавих, тайланг фото зургаар бэлтгэх, ажиллах хүчийг дэмжих, хүлэмжийг гүйцэтгэгчээс хүлээн авах.
- Гүйцэтгэгч: Хүлэмжийн зураг боловсруулах, барилгын техникийн хэрэгжилтийг хангах, байгаль орчинд ээлтэй материал ашиглан барилгын ажлыг чанарын өндөр түвшинд хийж гүйцэтгэнэ.

9. Төлбөр

- Төлбөрийг 3 хувааж гүйцэтгэгчид өгнө. (Тухайлбал, гэрээ зурагдсаны дараа материал худалдан авахад **50%**, **барилгын ажил эхлэх үед 40%**, **хүлэмж хүлээн авсны дараа 10% гэх мэт**. Энэ нь гэрээнд нарийн тусгагдана.
- Бүх зардалд е-баримт авсан байх ёстой.

10. Хяналт, үнэлгээ, тайлан

- Хүлэмжийн барилгын үйл явцыг цаг тухайд нь хянаж, төслийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд тусгаж баримтжуулна.
- Хоршооны гишүүд өөр өөрсдийн хүлэмжийн барилгын ажлын өдөр тутмын үйл явцыг хянаж, үр дүнгээ төсөлд тайлагнана.

11. Хууль, журмын хүрээнд ажиллах

- Холбогдох хууль тогтоомж, барилгын аюулгүй байдлын стандарт, ЭкоДэвшилт ТББ-ын худалдан авалтын зааварчилгааг дагаж мөрдөх.
- Байгаль орчны тогтвортой байдлын зарчим болон бусад холбогдох зарчмуудыг баримталж ажиллах.
- Хүлэмж баригдаж дууссаны дараах баталгаат хугацаа, эвдрэл, гэмтлийн засвар зэрэг заалтуудыг тусгах.

12. Тавигдах шаардлага

Зөвхөн дараах шаардлагыг хангасан этгээд үнийн саналаа өгөх эрхтэй:

- Улсын бүртгэлтэй аж ахуйн нэгж байх
- Гурван улирлын хүлэмж барих 2-оос доошгүй жилийн туршлагатай

13. Бүрдүүлэх материалууд

- ААНБ-ын танилцуулга
- Хүлэмж барих үнийн санал
- Ажил гүйцэтгэх хугацаа
- Хүлэмж барих зураг төсөл
- Төсвийн төсөл (материалын зардал, тээвэр, машин түрээс, нэг цагийн ажлын хөлс гэх мэт төсвийг задлах)



- Татварын болон хугацаа хэтэрсэн зээлийн өргүй лавлагаа
- Хүлэмжийг шилдэг туршлага, сайн технологи, чанар, стандартын дагуу газар дээр нь барина.

Материал хүлээн авах:

Дээр дурдсан материалуудаа PDF нэг файл болгон 2026 оны 3-р сарын 30-ны дотор info@ecodevshilt.org хаягаар “Гурван улирлын хүлэмж” нэртэйгээр Монгол хэл дээр илгээнэ үү.

Веб хуудас: ecodevshilt.com

Холбоо барих: 99094810, 99543881